



**ГЛОБ ИНТЕРНЭШНЛ ТББ  
САН**

**КОНРАД АДЭНАУЭРИЙН**

**2008 оны УИХ-ын сонгуулийн өмнөх  
ТОГТМОЛ ХЭВЛЭЛИЙН  
МОНИТОРИНГИЙН ТАЙЛАН**

Улаанбаатар хот.  
2008 оны 04-05-р сар

2008 оны УИХ-ын сонгуулийн өмнөх тогтмол хэвлэлийн  
мониторингийн тайлан

Гарчиг

Товчилсон нэрсийн жагсаалт .....	
Нэг. Өмнөтгөл.....	1-2
Хоёр. Мониторингийн үндэслэл.....	2
Гурав. Сонгуулийн өмнөх мониторингийн зорилт.....	3
Дөрөв. УИХ-ын сонгуулийн эрх зүйн орчин.....	3-4
Тав. Хэвлэл мэдээллийн мониторингийн арга зүй.....	4-6
Зургаа. Мониторингийн дүн.....	
6.1 Сонгуулийн мэдээллийн чиг хандлага.....	6-9
6.2 Мэдээллийн тэнцвэрт байдал.....	9-11
6.3 Мэдээллийн агуулгын эерэг, сөрөг байдал.....	11-12
6.4 ХМХ-ийн эффект.....	13-16
6.5 Бичлэгийн төрөл зүйл, эх сурвалж ашигласан байдал.....	16-17
6.6 Хөгжлийн гол асуудлуудыг тусгасан байдал.....	18-19
Долоо. Дүгнэлт, зөвлөмж.....	19
7.1 Дүгнэлт.....	19-20
7.2 Зөвлөмж.....	20
Мониторингийн баг.....	21
Найм. Хавсралт.....	
8.1 Боломжит нэр дэвшигчдийн нэрс.....	

## Товчилсон нэрсийн жагсаалт

МЧАСЭ	Монголын Чөлөөт Ардчилсан Сэтгүүлчдийн Эвлэл
МХХ	Монголын хэвлэлийн хүрээлэн
ХММ	Хэвлэл мэдээллийн мониторинг
УИХ	Улсын Их Хурал
ӨдС	Өдрийн сонин
Ө	Өнөөдөр
ЗМ	Зууны мэдээ
ЗШ	Зууны шуудан
ММ	Монголын мэдээ
НТ	Нийгмийн толь
УТ	Улаанбаатар таймс
ӨгС	Өглөөний сонин
Ү	Үнэн
А	Ардчилал
ӨМ	Өнөөдрийн Монгол
АЭ	Ардын эрх
МАХН	Монгол Ардын Хувьсгалт Нам
АН	Ардчилсан Нам
ИЗН	Иргэний Зориг Нам
АТН	Ард Түмний Нам
ҮШН	Үндэсний Шинэ Нам
МНН	Монголын Ногоон Нам
МУНН	Монголын Уламжлалын Нэгдсэн Нам
БНН	Бүгд Найрамдах Нам
МЛН	Монголын Либерал Нам
ИХН	Иргэний Холбоо Нам
МСДН	Монголын Социал Демократ Нам
ЭЧХН	Эрх Чөлөөг Хэрэгжүүлэгч Нам
ХААНН	Хүмүүнлэг Ардчилсан Ардын Нэгдсэн нам
МЛАН	Монголын Либерал Ардчилсан Нам
МҮЭНН	Монголын Үндэсний Эв Нэгдлийн Нам
АҮХТХ	Ардчилсан Үндсэн Хууль Тогтоогчдын Холбоо
МоАХ	Монголын Ардчилсан Холбоо
СЕХ	Сонгуулийн Ерөнхий Хороо

## Нэг. Өмнөтгөл

Өнөөдөр Монголд 400 шахам хэвлэл мэдээллийн хэрэгсэл үйл ажиллагаа явуулж байгаагаас өргөн нэвтрүүлгийн хэрэгсэл 80 шахам, өдөр тутмын 13 сонин ажиллаж байна. Зөвхөн Улаанбаатар хотод телевизийн бараг хориод суваг үйл ажиллагаа явуулж байгаа юм.

1998 онд батлагдсан Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулиар Монголд төр олон нийтийн мэдээллийн хэрэгсэл өмчлөх, мөн цензурыг хориглосон. ХМХ нийтэлж, нэвтрүүлж буй зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ. 2008 оны 6-р сард Монголд УИХ-ын ээлжит сонгууль болно. Монголын хэвлэл мэдээлэл энэ удаа ч УИХ-ын сонгуульд чухал үүрэг гүйцэтгэнэ. Хэвлэл мэдээлэл сонгуулийн үеэр үзэл бодлын индэр, мэтгэлцээний талбар болж, нэр дэвшигч, улс төрийн намуудын байр суурийг олон нийтэд ойлгуулж, зөв сонголт хийхэд тусалдаг. Энэ үүргээ хэвлэл мэдээлэл хэрхэн биелүүлэхээс улс орны ирээдүйн амьдрал ихээхэн шалтгаална.

"Глоб Интернэшнл" төрийн бус байгууллага 2008-03-14 ний өдрөөс 2008-04-04-ний өдрийг хүртэлх гурван долоо хоногийн хугацаанд өдөр тутмын 12 сонинд хийсэн сонгуулийн өмнөх мониторингийн тайланг танилцуулж байна. Энэ мониторинг нь хэвлэл мэдээллийн сонгуулийн сурталчилгааны дүр төрхийг тодорхойлох зорилготой, анх удаа албан ёсны сонгуулийн сурталчилгаа эхлэхээс өмнө хийснээрээ онцлогтой мониторинг юм.

Сонгуулийн кампанит ажлын үеэр МЧАСЭ 1996 онд анх удаа хэвлэл мэдээллийн мониторинг хийснээс хойш МХХ, "Глоб Интернэшнл" төрийн бус байгууллага сонгуулийн мониторингийг дагнан хийж байгаа юм.

2000 оны УИХ-ын сонгуулийн кампанит ажлын ид оргил үеэр МХХ,  
2004 оны УИХ-ын сонгуулийн сурталчилгааны сүүлийн долоо хоногт МХХ,  
2004 оны УИХ-ын сонгуулийн сурталчилгааны турш "Глоб Интернэшнл"  
төрийн бус байгууллага,  
2005 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгааны туршид "Глоб  
Интернэшнл" төрийн бус байгууллага тус тус ХМХ-д мониторинг хийсэн  
байна.

Эдгээр мониторингийн хугацаа, хүрээ, арга зүй өөр өөр байсан ч мониторингийн дүнгээс нэгдсэн дүгнэлт хийж болно.

- Монголын ХМХ-үүдийн сонгуулийн сурталчилгаа өөр хоорондоо ялгаатай боловч хэт өрөөсгөл байдал давамгайлж байсан
- Төрийн мэдлийн ХМХ-үүд тухайн үед эрх барьж байсан улс төрийн намын эрх ашигт түлхүү үйлчилж байсан.
- ХМХ-үүд сонгуулийг орлого олох эх үүсвэр гэж үзэж, мөнгөтөйд нь илүү үйлчлэх байдал давамгайлж байсан
- Сэтгүүлчид сонгуулийн үеэр талцаж, нам, нэр дэвшигчдийн сурталчилгааны багт ажиллаж байсан
- Улс төрийн төлбөрт сурталчилгаа, зар сурталчилгаа, мэргэжлийн сэтгүүл зүйн хоорондын ялгаа зааг олон нийтэд мэдэгдэхгүй байсан
- Мэдээ, мэдээллийн хөтөлбөр, сонины мэдээний зай талбайд нам, нэр дэвшигчийн сонгуулийн штабын мэдээг шууд зуучлан тавьж, төлбөр авч байсан

- Сонгууль болсон тухайн үед төрийн эрх барьж байсан хүчнээс ХМХ-ийн мэдээлэл ихээхэн хэмжээгээр хамааралтай байсан байна.

Сонгогчдын эрх ашигт илүү нийцсэн, тэдний хүсэн хүлээсэн мөрийн хөтөлбөрийн харьцуулалт, мэтгэлцээн, сонгуулийн явцад болж байсан чухал үйл явдлын учрыг тайлбарлан таниулсан, сонгуулийн булхайг илчилсэн зэрэг мэргэжлийн сэтгүүл зүйн материал өмнөх сонгуулиудын кампанит ажлын үеэр тун ховор байжээ.

## **Хоёр. Мониторингийн үндэслэл**

ХМХ нь сонгуулийн үед нэр дэвшигчид болон улс төрийн намуудын үзэл бодлыг олон нийтэд сайтар ойлгуулах үйлсэд үйлчлэх учиртай. Мөн сонгогчид өөрсдийн нь ашиг сонирхлыг төлөөлөх мандатыг аль улс төрийн хүчинд өгөхөө шийдэхэд шаардлагатай мэдээллийг хангалттай өгч туслах үүрэг ХМХ-д оногдоно. Өрсөлдөгч талуудыг харуулах, тэдгээрийн түүх намтар, улс төрийн мөрийн хөтөлбөр, үзэл бодол, хэтийн төлөвлөгөө, ирээдүйг харах чадвар зэргийг тайлбарлан таниулах юугаар ч орлуулшгүй үүргийг хэвлэл мэдээлэл чухам сонгуулийн үеэр л гүйцэтгэдэг.

Улс төрийн тухай мэдээлэл авах анхдагч эх сурвалж нь сонгуулийн үйл явц байдгийн хувьд сонгуулийг шударгаар явуулах, өрсөлдөгч талуудад өөрийн сурталчилгааг хийх, улс төрийн нам, нэр дэвшигчид болон улс төрийн ач холбогдол бүхий мэдээллийг танилцуулахад хэвлэл мэдээлэл үндсэн үүрэгтэй юм.

1. Сонгуулийн өмнөх нөхцөл байдлыг ерөнхийд нь шинжлэн дүгнэх үйл ажиллагааны чухал хэсэг нь хэвлэл мэдээллийн мониторинг юм. Энэ нь төр, өрсөлдөгч улс төрийн хүчнүүд хэвлэл мэдээлэлд хэрхэн хандаж байгаа хийгээд ХМХ сонгуульд өрсөлдөгчдийг хэрхэн харуулж буйг тооцон үнэлэх үр ашигтай арга хэрэгсэл юм.

2. 2005 онд УИХ-ын сонгуулийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт орж, сонгуулийн кампанит ажлын чухал хэсэг болох ХМХ-ийн сурталчилгаанд шинэ хязгаарлалт тогтоосон юм.

3. Хэдийгээр 2008 оны сонгуулийн сурталчилгаа албан ёсоор эхлээгүй ч иргэдийн анхаарлыг татаж буй улс төрийн хамгийн гол чухал үйл явдлын хувьд нийт хэвлэл мэдээллийн хэрэгсэл онцгой анхаарч байна.

Сонгуулийн өмнөх болон сонгуулийн кампанит ажлын сурталчилгаа нь сонгогчдын сэтгэл санаа, сонголтонд нөлөөлж байдаг ХМХ-ийн мэдээллийн хандлага, зан үйлийн тухай бодит мэдээлэлтэй байх нь олон нийтийн эрх ашигт нийцнэ.

### **Гурав. Сонгуулийн өмнөх мониторингийн зорилт**

Бид мониторинг хийх явцдаа дараахь зорилтыг тавьсан юм.

- ХМХ-ийн сонгуулийг тусгаж буй байдал, тухайлбал хандлага, зан үйлийн дүр зургийг харуулах
- Сонгуулийн мэдээллийн чиг хандлага, баримжааг үнэлэх
- ХМХ сонгуулийн өмнө аль хэр шударга, тэнцвэртэй мэдээлэл түгээж буйг үнэлэх
- Улс төрийн намуудын тавьж буй улс төр, нийгэм, эдийн засгийн гол гол асуудлыг тодорхойлох
- Болзошгүй нэр дэвшигчдийн нэр, тэдний нийгэмд илгээж буй мессежийг тодорхойлох
- Сонгуулийн албан ёсны кампанит ажлын үеэр ямар өөрчлөлт гарсныг харьцуулан дүгнэх

### **Дөрөв. УИХ-ын сонгуулийн хууль эрх зүйн орчин**

УИХ-ын сонгуулийн хэвлэл мэдээллийн сурталчилгаа дор дурдсан хууль, тэдгээрийн зохих зүйл заалтын хүрээнд явагдана. Үүнд:

- Үндсэн Хууль, 1992
- Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, 1998
- Олон нийтийн радио, телевизийн тухай хууль, 2005
- Зар сурталчилгааны тухай хууль, 2002
- Харилцаа, холбооны хууль, 2001
- Радио долгионы тухай хууль, 1999
- УИХ-ын сонгуулийн тухай хууль, 2005

2005 онд батлагдсан УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 8 дугаар зүйлд зааснаар “ Сонгуулийг санал авах өдрөөс 45-аас доошгүй хоногийн өмнө Улсын Их Хурал товлон зарлана”. Уг хуулийн 8.2-ын дагуу “Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн санал авах өдөр нь сонгуулийн жилийн зургадугаар сарын сүүлийн хагасын аль нэг ням гариг байна”.

Өнөөгийн байдлаар УИХ-ын сонгуулийн санал хураах өдрийн урьдчилсан тов нь 2008 оны 6 сарын 29-ний өдөр юм.

УИХ-ын сонгуулийн тухай хуульд буй, хэвлэл мэдээлэлтэй холбоотой чухал заалтыг дор дурдав.

### ***9 дүгээр зүйл. Сонгууль бэлтгэн явуулах ажлын ил тод байдал***

9.2. Сонгууль зохион байгуулж явуулах, түүний бэлтгэл ажилтай холбогдуулан энэ хуулиар олгосон эрхийн хүрээнд нийтээр дагаж мөрдүүлэхээр батлан гаргасан шийдвэр нь хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд албан ёсоор мэдээлэгдсэн байна.

9.3. Хэвлэл, мэдээллийн хэрэгсэл болон ийм үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага сонгуулийн үйл ажиллагааны талаар үнэн зөв, бодитой мэдээлэл түгээх үүрэгтэй.

Хуулийн 35 дугаар зүйлийн дагуу “ Нэр дэвшигчийг гүтгэх, доромжлох, нэр төрийг нь гутаах, түүний хувийн болон захидал харилцааны нууцыг задруулахыг хориглоно (35.3). Энэ зүйл заалтыг зөрчсөн тохиолдолд “ ...эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй байвал иргэнийг 100000-150000 төгрөгөөр, албан тушаалтныг

200000-250000 төгрөгөөр, нам, эвслийг 800000-1000000 төгрөгөөр, хэвлэл мэдээллийн болон бусад байгууллагыг 600000-800000 төгрөгөөр торгоно (35.6)

УИХ-ын сонгуулийн тухай хуульд олон нийтийн өргөн нэвтрүүлгийн хэрэгсэл ( үнэ төлбөргүй), арилжааны сувгууд тэнцвэртэй сурталчилгаа явуулах, сурталчилгаа нь нэвтрүүлгийн нийт хугацааны 10 хувиас хэтрэхгүй байх тухай тодорхой заасан. Харин сонин хэвлэлийн хувьд тодорхой үүрэг ногдуулсан зүйл заалт байхгүй юм.

#### **Тав. Хэвлэл мэдээллийн мониторинг /ХММ/-ийн арга зүй**

Сонины мониторингийг “Глоб Интернэшнл” төрийн бус байгууллагын таван хүний бүрэлдэхүүнтэй мониторингийн баг хийсэн болно. Гурван ажиглагч тус бүр дөрвөн сонины 10-22 дугаараас мэдээлэл цуглуулж, нэг гишүүн мэдээллийн тоон үзүүлэлтүүдийг тусгай програмд оруулж, нэгтгэн боловсруулж, нэг судлаач зөвлөхийн тусламжтайгаар мэдээлэлд дүн шинжилгээ хийж, тайлан бэлтгэсэн юм. Мониторингийн нийт дүнг тоон шинжилгээ, чанарын шинжилгээ, ХМХ-ийн нөлөөлөл гэсэн 3 хэлбэрээр хийсэн болно.

#### *Ì îîèòîðèíàèéí òòààòàà, òàì àðíàì òýðýý*

Мониторингийг 2008-03-14 ний өдрөөс 2008-04-04-ний өдрийг хүртэлх гурван долоо хоногийн хугацаанд гарсан доорх нэр бүхий 12 сонины 10-22 дугаарт хийсэн болно.

1. Өнөөдөр, долоо хоногт 6 удаа
2. Өдрийн сонин, долоо хоногт 6 удаа
3. Зууны мэдээ, долоо хоногт 6 удаа
4. Зууны шуудан, долоо хоногт 6 удаа
5. Нийгмийн толь, долоо хоногт 6 удаа
6. Монголын мэдээ, долоо хоногт 5 удаа
7. Улаанбаатар таймс, долоо хоногт 5 удаа
8. Өглөөний сонин, долоо хоногт 5 удаа
9. Үнэн, долоо хоногт 5 удаа
10. Ардчилал, долоо хоногт 5 удаа
11. Өнөөдрийн Монгол, долоо хоногт 5 удаа
12. Ардын эрх, долоо хоногт 5 удаа

Дээрх нэр бүхий сонинуудаас “Үнэн”, “Ардчилал” сонин нь одоо УИХ-д олон суудалтай, улс төрийн гол хүчин болох МАХН, АН-ын хэвлэл юм. Бусад нь хувийн сонин байна.

#### *Ì îîèòîðèíàèéí àðàà-èàè*

Мониторингийн үеэр улс төрийн намууд, сонгуульд нэр дэвшихээр горилогсодод өдөр тутмын сонинуудын зүгээс зориулсан цагийг тоо, чанарын хувьд тооцож гаргав.

Сонгуулийн мэдээллийн бүхий л хэлбэрийг тоо, чанарын хувьд тооцох боломжгүй учраас байгууллагаас ХМХ-ийн зүгээс хэрэглэсэн арга заль, нэг талыг

баримталсан байдал, ёс зүйн асуудлыг тэмдэглэх тусгай категори /ай/ бий болгож түүнийгээ *ÕÌ Õ-èéí ýôôâêò /íëëëëëë/* хэмээн нэрлэсэн юм.

Сонгуулийн мэдээлэлд тоо ба чанарын шинжилгээ хийж, ХМХ-ийн нөлөөллийн тодорхой жишээнүүдийг гаргаж ирэх нь улс төрийн өрсөлдөгчдийн талаар нийтлэгдсэн мэдээлэл шударга, тэнцвэртэй байгаа эсэх тухай өргөн олон түмэнд хүргэх зорилготой чухал үйл ажиллагаа юм.

Сонинд мэдээлсэн сонгуулийн мэдээлэл тэнцвэртэй, шударга сэтгүүл зүйн үндсэн дүрэмд нийцэж байгаа эсэхийг тогтоохын тулд мониторингийн баг тоон болон чанарын шинжилгээ хийв.

### *ÕÌÍÍ Õèíæèëäýý*

Тоон шинжилгээ нь гэдэг нь ажиглалт хийхээр сонгосон сэдэв, субъект /этгээд/-эд ХМХ-ээс зориулсан нийт цаг, талбайг хэмжих явдал юм. Сонинуудын хувьд улс төрийн этгээдэд зориулсан талбайг см<sup>2</sup>-аар тооцов. Тухайн субъектын талаар шууд бусаар (дам) дурдсан бүх тохиолдлыг мөн хамруулж, *äóðäñàí/òýì äýäëýæ òýëñýí* (1 см<sup>2</sup>) гэдэг зүүлтгэйгээр тоон болон чанарын шинжилгээний аль алинд нь хамруулж маягтад орууллаа.

### *×àíàðýí Õèíæèëäýý*

Чанарын шинжилгээгээр улс төрийн намууд болон 2008 оны УИХ-ын сонгуульд нэр дэвших магадлал бүхий хүмүүсийн талаар мэдээлсэн зүйлийн агуулга нь эерэг, сөрөг буюу нейтрал ямар байгааг үнэлсэн юм. Ингэхдээ бүх нам болон мониторингийн явцад сонгуультай холбоотой гарч ирсэн бүх хүмүүст сонинууд хэрхэн хандаж байгаад үнэлгээ өгсөн бөгөөд энэ нь тэдгээрт зориулсан талбайн хэмжээ болон тухайн этгээдийг хэрхэн харуулсан талаар мэдээлэл болж өгсөн юм.

Үнэлгээ нь 5 шатлалт хэмжээтэй байв. Тухайн улс төрийн этгээдийг маш эерэг буюу магтсан, биширсэн байдалтай бөгөөд мэдээлэл нь эерэг сэтгэгдэл, сэтгэлийн хөдөлгөөн агуулсан бол 1, хэт магтан биширсэн биш ч эерэг мэдээлийг агуулсан бол 2 гэсэн үнэлгээ өгөв.

Улс төрийн этгээдийн талаар баримттай, сэтгэл хөдлөлгүйгээр буюу нейтрал байдлаар үзүүлсэн бол 3 гэсэн оноо өгсөн.

Тухайн улс төрийн нам, хүнийг илт муулсан, сөрөг сэтгэлийн хөдөлгөөн, буруутгасан буюу нэг талыг барьсан байдалтай бол маш сөрөг буюу 5, ерөнхийдөө муулсан, сөрөг сэтгэгдэл төрүүлэхээр бол 4 гэсэн үнэлгээг өгсөн. Тухайн этгээдийн талаархи үнэлгээг хийхдээ өргөн сонголттой байх боломжийг ажиглагчдад олгохын тулд энэхүү 5 шатлалт хэмжээсийг ашигласан боловч нэгтгэн дүгнэхдээ эерэг, сөрөг, нейтрал гэсэн гурван үндсэн байдлаар дүгнэлээ.

Мониторингод хамрагдсан сонинууд үйл явдал, улс төрийн хүчин, хувь хүнд тэнцвэртэй, шударга, бодитой хандаж байгаа эсэхийг бүх этгээдэд өөрийн үзэл бодлыг илэрхийлэхэд нь адил талбай, боломж олгосон байдлаар нь дүгнэсэн болно.

### *ÕÌ Õ-èéí ýôôâêò /íëëëëëë/*

Дээр өгүүлсэн тоон болон чанарын хувьд алинаар нь ч тооцох боломжгүй, бичлэгийн тодорхой төрөл зүйлд оруулахад хэцүү, олон нийтэд нөлөөлөхийг оролдсон онцой бичвэрүүдийг тэмдэглэхдээ ХМХ-ийн эффект хэмээх тусгай

категорийг ашиглав. Тухайн материалд “тодорхой, ил тод, баримттай, тэнцвэртэй, олон талт, цаг үеэ олсон, энгийн, ойлгомжтой” зэрэг шалгуурууд байхгүй, сэтгүүл зүйн үндсэн зарчим, стандартыг илэрхий агуулаагүй гэж үзсэн тохиолдолд энэхүү үнэлгээг өгсөн болно.

## Зургаа. Мониторингийн дүн


### 6.1 Мониторингийн мэдээллийн байдал, чиг хандлага

УИХ-ын сонгуулийн сурталчилгаа албан ёсоор эхлээгүй боловч улс орны хувь заяатай холбоотой улс төрийн гол үйл явдлын хувьд өдөр тутмын хэвлэлүүд үүнд ихээхэн анхаарал хандуулж байна.

Мониторингийн хугацаанд нийт 12 сонинд сонгуультай холбоотой 2255 тооны материал хэвлэгдэж, нийт 36 273 см<sup>2</sup> талбай зориулжээ.

Мониторингод хамрагдсан сонинуудаас өдөр тутмын 2 сонин, Ардчилал, Үнэн зэрэг нь намын харьяалалтай сонинууд бөгөөд Ардчилал сонин нэг дугаарынхаа нийт талбайн дунджаар 3,3 хувь, Үнэн сонин нэг дугаарын нийт талбайн дунджаар 2,4 орчим хувийг сонгуулийн асуудалд зориулж байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт юм.

График № 1. Сонгуультай холбоотой материалд зориулсан талбайн хэмжээ /см<sup>2</sup>/



Харин Улаанбаатар таймс сонин нэг дугаарын нийт талбайн дунджаар 0,8 хувь, Өнөөдөр сонин 0,7 хувь, Өглөөний сонин 0,3 хувийг тус тус сонгуультай холбоотой материал нийтэлсэн нь хамгийн бага үзүүлэлт байна.

Мониторингод хамрагдсан өдөр тутмын бүх сонин өдөр бүрийн дугаартаа уг сэдвийг хөндсөн байна. Зарим сонин тусгай булан хүртэл нээжээ. Тухайлбал: Өнөөдрийн Монгол сонин “Лүндээгийн ангийнхны 76 өнгө төрх”, Өглөөний сонин “Ордны шивнээ”, Зууны мэдээ сонин “Би сонгохгүй”, Улаанбаатар таймс сонин

“Сонгогчийн үг” Нийгмийн толь” сонин “Хэн нь хэн бэ?”, Ардын эрх сонин “Хөндөх сэдэв”, “Захидал ирлээ” зэрэг буланд УИХ-ын одоогийн гишүүд, 2008 онд УИХ-д сонгогдох боломжит нэр дэвшигчдийн тухай цуврал материалууд нийтэлжээ.

Мониторинг хийсэн хугацааны 3 долоо хоногийн ажиглалтыг дотор нь харьцуулан үзвэл, “Монголын мэдээ”, “Үнэн”, “Өнөөдөр”, “Өдрийн сонин”, “Өглөөний сонин”, “Өнөөдрийн Монгол”, “Зууны мэдээ”, “Ардчилал” сонинд сонгуулийн холбогдолтой материалууд тогтвортойгоор нэмэгдэх хандлагатай байна. Бусад сонинны хувьд тогтвортой, нэгэн түвшинд байна. Үүнийг доорх хүснэгтээр харуулав.

**Хүснэгт №1. Материалын өссөн байдал /нийт материалуудын дунджаар тооцов/**

	1-р долоо хоног	2-р долоо хоног	3-р долоо хоног
НТ	12	28	19
ММ	9	13	30
Ү	12	17	21
Ө	12	10	22
ӨдС	20	16	30
ӨгС	7	7	11
ӨМ	14	7	20
ЗШ	26	24	22
ЗМ	19	18	23
УТ	11	3	7
А	4	10	24
АЭ	10	17	16

Мониторингод хамрагдсан сонинуудад нийтэд нь “төлбөртэй” гэсэн тодотгол бүхий материал судалгаагаар гарч ирээгүй бөгөөд үүнийг бид сонгууль болон сонгуулийн сурталчилгаа албан ёсоор зарлагдаагүй байгаатай холбоотой хэмээн ойлгож болох юм. Гэхдээ тухайн материалын үнэхээр төлбөргүй эсэхийг магадлах боломжгүй байна.

Мониторингод хамрагдсан сонинуудад хэвлэгдсэн материалууд нь ерөнхийдөө

- улс төрийн намуудын тухай,
- нэр дэвшихээр горилогсдын тухай,
- сонгогчдын боловсролд чиглэсэн гэсэн гурван хэлбэртэй байна.
- **Улс төрийн намуудын тухай**

Мониторингод хамрагдсан сонинууд сонгуультай холбоотой материалдаа засгийн эрх барьж буй МАХН, сөрөг хүчний гол нам болох АН хоёрын тухай түлхүү нийтэлж байгаа ч нийт сонинуудад одоо албан ёсоор бүртгэлтэй улс төрийн хүчнүүд ямар нэг хэмжээгээр дурдагджээ.

Мониторингийн хугацаанд нийтлэгдсэн 2255 материалын 8 нь СЕХ ба сонгогчидтой холбоотой, 399 нь улс төрийн намуудын тухай, 1848 нь тухайлсан хэн нэгэн хүнтэй холбоотой материал байна.

- **Нэр дэвшихээр горилогсдын тухай**

Мониторингийн дүнгээс үзвэл одоо УИХ-д байгаа болон ирэх сонгуульд сонгогдож болзошгүй олон хүний нэрийг сонинууд таамаг байдлаар оруулж ирсэн байна. Үүнээс тооцож үзэхэд нийт хүний нэрийг боломжит нэр дэвшигчийн тоонд оруулж болохоор байна.

Ийнхүү гарч ирсэн боломжит нэр дэвшигчдээс намын харъяаллаар нь авч үзвэл эрх барьж буй МАХН-ын гишүүн, дэмжигч 107 хүн, АН-ын гишүүн, дэмжигч 59 хүн, бусад нам, холбоодын гишүүн 122 хүн байна.

Нэр дэвшигчид албан ёсоор тодорч, тэдгээрийн мөрийн хөтөлбөр ил тод болоогүй байгаатай холбоотойгоор нэр дэвшихээр горилогсдын нийгэмд илгээж байгаа мессежийг тодорхойлох боломжгүй байна.

- **Сонгогчдын боловсролд зориулсан материал**

Нэгэнт улс орны гол үйл явдал болох сонгуулийн тухай анхаарч байгаатай холбоотойгоор СЕХ-ны үйл ажиллагаа болон сонгогчдод зориулсан материалууд бас нийтлэгджээ. СЕХ-ны үйл ажиллагаанд шүүмжлэлтэй хандсан, зөвлөмж өгсөн хандлагатай нийт 8 материал хэвлэгдсэн байсан нь 2982 см 2 талбай эзэлж байна. Энэ нь нийт бичвэрийн талбайн 8 хувь болж байгаа юм. Эдгээрийн 5 нь мөн сонгогчдын боловсрол, мэдээлэлд нэмэр болохуйц мэдээ, нийтлэл байлаа. Жишээлбэл:

- Монголын Мэдээ сонинд Азийн сангийн Сонгууль, улс төрийн асуудал хариуцсан бүсийн захирал Тим Тайсбургтэй хийсэн ярилцлага нийтэлж бусад улс орон сонгуулийн асуудалд хэрхэн анхаардаг талаар мэдээлэл өгсөн.
- Өнөөдрийн Монгол сонин 2008-03-26, 27-ны дугаартаа “Сурталчилгааны дажин” материалдаа сонгууль албан ёсоор зарлагдаж сурталчилгаа албан ёсоор явж эхлээгүй байхад зарим хүмүүс ил сурталчилгаа хийж хууль зөрчиж, сонгогчдын санаа бодолд нөлөөлөхийг оролдож байгааг болон СЕХ муу ажиллаж, хяналт тавихгүй байгааг шүүмжлэн ард иргэдэд хууль бус сурталчилгаанд автахгүй байхыг уриалсан.
- Өглөөний сонин 2008-03-21-ний дугаартай “АТГ-ын хөрөнгө орлогын мэдүүлэгт хяналт тавьдаг газар байна уу?” нийтлэлдээ хуулийн дагуу зээлтэй иргэд УИХ-д нэр дэвших ёсгүй атал хөрөнгө орлогын мэдүүлэгтээ хэдэн арав, зуун саяын зээлтэй хэмээн тэмдэглүүлсэн УИХ-ын одоогийн гишүүд, нэр дэвшиж магадгүй төрийн албан хаагчид олон байгааг дурдан, ийм их хэмжээний зээлтэй хүн нэр дэвшвэл хууль зөрчсөн хэрэг болохыг иргэдэд сануулжээ. Уг материалд Сонгуулийн хууль ба түүний хэрэгжилт ямархуу байгааг харьцуулан гаргасан байна.
- Зууны мэдээ сонин 2008-03-18-ны өдрийн дугаараас эхлэн “Би сонгохгүй” булангаараа “Сонгогчийн эрх хөсөрдөнө буюу 4 нэмэх” гэсэн цувралыг тавьж эхэлсэн. Уг буланд УИХ-ын гишүүн болж төр түшицэх хүмүүс ажил мэргэжлийн, нийгмийн нэр хүндийн, хувь хүний хувьд ямар хүн байх

хэрэгтэй вэ гэдэг талаар мэргэжилтнүүд, судлаачид, иргэдийн саналыг авч, ард түмэн ямар хүнээр хууль тогтоолгож, төр бариулах хүсэлтэй байгааг илэрхийлж байна.

- Улаанбаатар таймс сонин 2008-04-04-ний дугаартаа “Сонгууль ба улс төрийн хүчнүүд” нийтлэлдээ өнөөдөр Монгол улсад хүчин төгөлдөр үйл ажиллагаа явуулж буй улс төрийн хүчнүүдийн талаар мэдээлэл өгч, мөн тэдгээр нам эвслүүд зөвхөн өөрийн дотоод эрх ашигт иргэдийн эрх ашгаас илүү анхаарал хандуулж байгааг шүүмжилсэн.


## 6.2 Мэдээллийн тэнцвэрт байдал

Судалгаанаас үзэхэд нийт сонинууд мэдээллийн тэнцвэрт байдлыг хангаж чадаагүй болох нь тоон үзүүлэлтээс харагдаж байна. Учир нь нийт сонинууд эрх баригч МАХН, сөрөг хүчний АН-ын тухай хамгийн ихээр нийтэлсэн атлаа бусад нам хүчнүүдийн тухай дурдах төдий өнгөрчээ.

Одоогоор Монгол улсад албан ёсоор бүртгэлтэй 15 нам байдаг ажээ. Эдгээрээс нийт материалд МАХН-ын тухай болон МАХН-ын гишүүдийн тухай материал 18585 см<sup>2</sup>, АН-ын тухай болон гишүүдийн тухай материал 10890 см<sup>2</sup> талбай эзэлсэн байхад ҮШН, АТН, Эх Орон нам, БНН, МУНН, МЛН, ЭЧХН, ХААНН зэрэг намуудын тухай гарсан материал нь нийт эзлэх талбайн 1 хувьд ч хүрэхгүй байгаа юм.

Нийт сонинуудын улс төрийн хүчнүүд рүү анхаарал хандуулсан байдлыг доорх графикт харуулав. Бусад намууд гэсэн үзүүлэлт дотор бусад жижиг намууд, улс төрийн эвлэл, холбоодын гишүүд болон нам бус хүмүүс, боломжит бусад нэр дэвшигчдийн тухай нийт материал багтсан болно.

**График 2. Улс төрийн хүчнүүдийн талбай эзэлсэн байдал**



Мониторингийн явцад хэвлэгдсэн нийт материалаас үзэхэд сонинууд нам, улс төрийн хүчнүүдийн лидерүүдэд ихээхэн зай, талбайгаа зориулсан нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл бүх намын дарга нарын тухай хамгийн их материал нийтлэгджээ.

Намын гишүүнчлэлээр нь тооцож үзвэл эрх баригч МАХН-ын дарга С.Баярын тухай хамгийн их материал буюу 5147 см<sup>2</sup> талбайд 76 материал нийтлэгдсэн байна. Үүний 17 нь С.Баярын тухай эсрэг, 31 нь сөрөг, 28 нь нейтрал

шинжтэй байна. С.Баярын тухай Өнөөдөр сониноос бусад бүх сонин 1-5 удаа материал нийтэлжээ. С.Баяраас гадна МАХН-ын бусад гишүүдээс сонинуудын анхаарлыг татсан хүмүүс нь Э.Мөнх-Очир, Сү.Батболд, Ё.Отгонбаяр, Ц.Шаравдорж, У.Хүрэлсүх, нар байна. Тэдний тухай тус бүр 1500-3800 см<sup>2</sup> талбайд мэдээ, нийтлэл хэвлэгдсэн байна.


Харин нөгөө нэг том нам болох АН-ын лидер Ц.Элбэгдоржийн тухай сонинууд 1842 см<sup>2</sup> талбайд 51 материал нийтэлсэн байна. Үүний 2 нь эерэг, 18 нь сөрөг, 31 нь нейтрал материал байна. Ц.Элбэгдоржоос бусад АН-ын гишүүдээс Лу.Гантөмөр, Л.Гансүх нарын тухай хэвлэлүүд хамгийн их буюу 1569 см<sup>2</sup>, 1281 см<sup>2</sup> талбайд мэдээлэл бичсэн байна.

Монголын мэдээ сонин МАХН-ын гишүүн Ч.Авдай, АН-ын гишүүн Р.Гончигдорж нарын тухай тус бүр 2919 см<sup>2</sup>, 2520 см<sup>2</sup> талбай эзэлсэн томоохон эерэг нийтлэлүүд гарсан байна.

Одоо УИХ-д суудалтай бусад намуудаас намын дарга болон нэр хүндтэй ганц нэг гишүүд, жишээлбэл, ИЗН-ын дарга С.Оюун, БНН-ын дарга, Б.Жаргалсайхан, Эх Орон намын дарга Б.Эрдэнэбат, АТН-ын дарга Л.Гүндалай, ИХН-ын дарга Ж.Батзандан, МоАХ-ны дарга Х.Баттулга ҮШН-ын дэд дарга М.Энхсайхан зэрэг хүмүүсийн тухай хэвлэлүүд мөн бичсэн байна.

2004 оны УИХ-д бие даан нэр дэвшсэн гишүүдээс УИХ-ын гишүүн Д.Одхүүгийн тухай сонинууд хамгийн их буюу 932 см<sup>2</sup> талбайд 13 материал нийтэлсэн байна.

**График № 3. Намын лидерүүдэд зориулсан талбай /см<sup>2</sup>-аар/**




Түүнчлэн 2008 оны УИХ-д нэр дэвших магадлал бүхий хүмүүсийн тухай бүх сонинууд зохих хэмжээнд дурдсан байгаагаас нэгтгэн харвал боломжит нэр дэвшигчдийн тоонд МАХН-ын гишүүн 107, АН-ын гишүүн 59, ҮШН-ын гишүүн 8, ИЗН-ын гишүүн 4, ИХН-ын гишүүн 4, МУНН-ын гишүүн 3, Эх орон намын гишүүн 4, бусад нам, холбооны гишүүн нийт 10, улс төрийн харъяалал тодорхойгүй 89 хүн байна.

Боломжит нэр дэвшигчдийн дотор нам бус хүмүүс, зарим нь одоо УИХ-ын гишүүн, зарим нь шинээр гарч буй 5 хүний нэр дурдагдсан бөгөөд улс төрийн аль нам, холбооны гишүүн болох нь тодорхойгүй 40 хүний нэрс гарч ирсэн байна. Мониторингийн хугацаанд ажиглалтанд хамрагдсан байдлаас дүгнэлт хийн гаргасан дээрх боломжит нэр дэвшигчдийн жагсаалтыг хавсралтаар гаргав.

### 6.3 Мэдээллийн агуулгын эерэг, сөрөг байдал

Судалгааны тоон үзүүлэлтээс үзэхэд нийт сонинуудад нийтлэгдсэн хувь хүний тухай бичвэрийн дийлэнх нь сөрөг шинжтэй байгаа бол улс төрийн намуудын тухай нейтраль буюу төвийг сахисан байдалтай материал давуу байна.

График № 4. Мэдээллийн эерэг сөрөг байдал



Нийт сонинуудын анхаарлын төвд хамгийн том хоёр нам болох МАХН, АН-ын тухай хамгийн их нийтлэгдсэн бөгөөд хамгийн их сөрөг мэдээллийг МАХН-ын эсрэг, хамгийн их эерэг мэдээллийг мөн МАХН-ын тухай бичжээ.

Хэдийгээр улс төрийн намуудын тухай нийт материалын дийлэнх нь ийнхүү төвийг сахисан байдалтай байгаа ч сонинууд нийтдээ, түүн дотор Өглөөний сонин, Улаанбаатар таймс, Өнөөдрийн Монгол, Нийгмийн толь, Ардын эрх сонинууд бүх улс төрийн хүчинд жигд шүүмжлэлтэй хандаж байгааг судалгаа нотолж байна.

Мэдээллийн чанарын хувьд ганц Өнөөдөр сонин эерэг, сөрөг аль ч хандлагыг аль ч улс төрийн хүчинд түлхүү хандуулаагүй байна. Мониторинг хийх явцад тус сонин болсон улс төрийн аливаа асуудлыг зөвхөн мэдээлж байснаас өөрөөр аль нэг нам хүчнийг дэмжсэн болон эсэргүүцсэн, ХМХ эффектийн шинжтэй нэг ч материал нийтлээгүй байна.

Харин, мониторингод хамрагдсан сонинуудаас Ардчилал, Үнэн зэрэг намын харъяалалтай сонинууд өөрийн намын тухай материалыг эерэгээр, бусад нам хүчнүүдийн тухай голдуу сөрөг материал нийтэлсэн нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл, Үнэн сонинд АН-ын тухай хамгийн олон сөрөг мэдээлэл, шүүмжлэлт материал, харин Ардчилал сонинд МАХН-ын тухай хамгийн их шүүмжлэлт болон сөрөг материалууд гарчээ. Жишээ нь:

Үнэн сонин 2008-03-14-ний дугаарт “Тунхаглалын шинжтэй амлалтууд тунхаглал хэвээрээ үлдэнэ”, 2008-03-26-ны дугаарт “АН ашигт малтмалын бодлогыг хойш чангаасаар байх уу?”, 2008-03-27-ны дугаарт “АН-д улс орны байтугай өөрийн эрх ашиг гэж юм ч үлдсэнгүй”, 2008-04-03-ны дугаарт “Санал луйвардах ченжүүд

хөлхөлдөж эхлэв” зэрэг нийтлэлд АН-ын тухай, мөрийн хөтөлбөр, бодлого, үнэт зүйлсийн нь талаар илт шударга бус байдлаар нийтэлсэн байхад Ардчилал сонины 2008-03-20-ны дугаарт “У.Хүрэлсүхгүй МАХН”, “Уургалагч нь У.Хүрэлсүх, уутлагч нь МАХН”, “Амлалт биелэлт, тайлбарын ид шид 100 хоногт”, 2008-03-26-ны дугаарт “Тулгамдсан асуудлаас зайлсхийсэн сонгуулийн шоу”, “2008-03-31-ний дугаарт “МАХН-ын нэр дэвшигчид мандатаа булаацалдаж нэгийгээ хутгалав”, 2008-04-01-ний дугаарт “Дарга нар улс төржөөд хариуцлага алдаж байна”, 2008-04-02-ны дугаарт “Хариуцлагагүй байсан ч сонгууль өнгөртөл хамаагүй”, 2008-04-04-ний дугаарт “Хариу нь олдохгүй бас нэг тэгшитгэл” зэрэг МАХН-ын тухай сөрөг мэдээ, нийтлэлүүдийг нийтэлжээ.


Бусад сонины байдлыг авч үзвэл:

Өдрийн сонин ерөнхийдөө МАХН-ын эсрэг шинжтэй,

Зууны мэдээ сонин АН-ын эсрэг шинжтэй материал түлхүү нийтэлж байна. Жишээ нь:

Өдрийн сонины 2008-03-17-ны дугаарт “Хууль тогтооход хусуур илүүц”, 2008-03-29-ний дугаарт “Гахай МАХН хоёр адилхан юм”, 2008-04-01-ний дугаарын хошин зургийн зохиомжинд МАХН-ыг голчлон оруулсан зэрэг МАХН-ын эсрэг, Зууны шуудан сонины 2008-03-14-ний дугаарт “АН-ын яршиг”, 2008-03-25-ны дугаарт “Ичиг, ичиг, ичиг”, мөн дугаарт “Хар пиар, өөр юу ч биш”, 2008-04-03-ны өдөр “Дөрвөн жилийн нэгэн” зэрэг АН-ын эсрэг нийтлэлүүд гарчээ.

**График № 5. Мэдээллийн агуулгын чанар**



#### 6.4 ХМХ-ийн эффект /нөлөөлөл/

Ажиглалт хийсэн нийт сонины бичвэрийн 90 гаруй хувь нь сэтгүүлчийн нэр, зохиогчгүй, редакцийн зурвасын чанартай байна. Түүнчлэн зарим сонин сонгогчийн үг, захидал зэрэг булан нээсэн бөгөөд ихэнх сөрөг мэдээ, нийтлэлүүд энэ хэлбэрийн буланд нийтлэгдэж байгаа юм. Мониторингийн хугацаанд нийтлэгдсэн материалуудын ХМХ нөлөөллийн шинжтэй мэдээ нийтлэлээс доор түүвэрлэн харуулав.

МАХН-ын доторх “Шударга ёс” бүлгийн гаргасан мэдэгдэл, шаардах бичиг, түүнтэй холбоотой ярилцлагыг өдөр тутмын 4 том сонин нийтэлжээ. Энэхүү шаардах бичиг нь МАХН, АН хоёрыг шүүхэд өгөх тухай юм. Энэ нь иргэдийн сэтгэхүйд зүй ёсоор нөлөөлөх бөгөөд шүүхэд мөрдөгдөж буй хүн, улс төрийн нам ч сонгуульд өрсөлдөх боломжгүй тул хүн амын дотор эргэлзээ, цуу үг бусад үр дагавар гаргах магадлалтай юм.

- Хүмүүсийн тухай бичсэн сөрөг материалуудын ихэнх нь зохиогчийн нэр тавигдаагүй байна. Тэдгээрийн дотор сэтгүүлчийн ёс зүйг зөрчсөн, хүнийг хэл амаар доромжилж нэр хоч өгч бичсэн мэдээ, нийтлэлүүд ч байна. Жишээ нь:

Монголын мэдээ сонины 2008-04-03-ны өдрийн дугаарт “Хэлгүй короля\*- будаа идэв” хэмээх нийтлэлд УИХ-ын гишүүн Лу.Гантөмөрийг “Хэлгүй короля”, Өдрийн сонины 2008-03-17-ны дугаарын “Хууль тогтооход хусуур хэрэггүй” нийтлэлд МАХН-ыг “морь амтай хусуур нам”, мөн сонины 2008-09-29-ний дугаарт “Тахай МАХН хоёр ижил юм”, Өнөөдрийн Монгол сонины 2008-03-20-ны дугаарын “Зөв явсаар зөөлөн суудалд тухалсан түшээ” нийтлэлд УИХ-ын гишүүн Б.Бат-Эрдэнийг “хэлгүй”, Өглөөний сонины 2008-03-14-ний өдрийн дугаарын “Гологдсон хүүхэн хуучин нутагтаа хайр зарлав” мэдээнд УИХ-ын гишүүн Д.Туяаг “Гологдсон хүүхэн” хэмээн хочилжээ.

2008-03-17-ны Зууны мэдээ сонинд СЕХ дарга МАХН Б.Баттулгад “хэлгүй короля” нэр хайрлав, “Лүймэдийн биш, Бүүмэдийн Гансүх”, “Короля Цэрэнбалжир” гэхчлэн бичсэн байна.

Мөн Зууны шуудан сонины 2008-03-14-ний дугаарын мэдээнүүдэд УИХ-ын гишүүн Ш.Батбаярыг “шулга Батбаяр”, УИХ-ын гишүүн З.Энхболдыг “бэлтрэг Энхболд”, Нийгмийн толь сонины “Сайдууд тулаанд бэлтгэж завгүй байна” нийтлэлд сайд Х.Наранхүүг “Хулхи Наранхүү”, мөн сонины 2008-03-22-ны дугаарт “Чуулганы дуу хураагуур” хэмээх мэдээнд Б.Эрдэнэсүрэнг “Нямдорж гишүүний дуу хураагуур” гэж хочилсон байна.

Ардын эрх сонины 2008-03-25-ны дугаарт “Лүндээ даргын улаан горшок” хэмээх материалд “... Гишүүдээс ганцаараа сонгогдсон тойрогтоо дөрвөн жилийн хугацаанд тэрбум хүрэхгүй төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн Д.Лүндээжанцан даргын дор ганцааранг нь улаанаар тэмдэглэснийг харсан өвөрхангайчууд УИХ-ын даргыгаа өхөөрдөж “улаан горшок” нэр хайрлажээ...” гэжээ.

---

\* Хэлгүй Короля- МУТВ-ээр гарч байсан Венесуэлийн телевизийн “Халтар царайт” олон ангит киноны баатар

- Мониторинг хийгдэх хугацаанд хэд хэдэн сонинд сөргөөр бичигдсэн цөөн хүн байна. Энэ нь тухай хүний үг хэл, үйлдэл нь олон нийт хэвлэл мэдээллийн анхаарлыг татсанаар ийнхүү бичигджээ. Жишээлбэл УИХ-ын гишүүн, АН-ын ҮЗ-ийн дарга Л.Гансүхийн тухай 5, УИХ-ын гишүүн Д.Одхүүгийн талаар 4, УИХ-ын гишүүн Лу. Гантөмөрийн талаар 3 материал нийтэлжээ. Эдгээр нь Л.Гансүх, Д.Одхүү, Л.Гантөмөр нарын талаарх

уншигчдын үнэлэлт, дүгнэлт, сонгогчдын сэтгэхүйд ч нөлөөлөхүйц материалууд юм.

УИХ-ын гишүүн Л.Гансүхийн талаар Үнэн сонины 2008-03-26-ны өдрийн “Тойроггүйдэхийн зовлон” нийтлэлд “... Муу Л.Гансүх тойрог олддоогүйдээ шаралхаж төсөл унагах гэж байна...”, Ардын эрх сонины “Үг хэл, үс зүсээрээ өрсөлдөж байхад” гэдэг нийтлэлд “...УИХ дахь АН-ын зөвлөлийг Л.Гансүхээр төлөөлүүлэн хардаг болсон сонгогчдынхоо нүдэнд тэрээр “намын хорооныхондоо жийгдсэн нөхөр” болж харагдахыг хүссэн юм байх даа. Тэгээд ч зогсохгүй түүнийг навч, нахиа гэж гоёор төсөөлбөл өөрийнх нь мод, мөчир болох АН-ынхаа нэр хүндийг давхар хөрөөддөг нь бүүр ч утгагүй хэрэг...”, Үнэн сонины 2008-03-28-ны дугаарт “Худал үнэн хоёр хүзүү толгой холбон уралдаж байна” нийтлэлд “... Л.Гансүх... Ашигт малтмалын хуулийн төсөлд ЗГ стратегийн орд газрыг тогтоох заалт оруулж эрх мэдлээ хэтрүүлсэн, өмнөх хуульд байсан чухал заалтууд алга болсон, АН-ын Зөвлөлийн хуулийн төсөлд өгсөн санал тусаагүй... гэж худал хэлэв. ..”Худалч ...”, гэвч өнөөдөр хуулийн төслөө тойрч худал үнэн ярьж, монголчуудын эрх ашиг гэсэн том шалгуураа уландаа гишгэн шоудаж..., шоуны манлайг тэргүүлж, төрийн ордонд худал үгийг чалчиж яваа Л.Гансүхийн ирэх сонгуулийн өмнөх рейтинг уналаа. Ганц түүний рейтинг унах ч яах ва, АН-ын нэр хүнд, түүнээс хэд дахин илүү олны эрх ашиг гэж байна...” хэмээн бичсэн байна.

УИХ-ын гишүүн Лу.Гантөмөрийн тухай “Монголын мэдээ” сонинд “хэлгүй короля будаа идэв” хэмээх нийтлэлд “өөрөө санаачлагагүй, дөрвөн жил амаа хамхиж явчихаад зөвхөн сонгууль дөхөхөөр хүний санааг өөрийн болгосон”, Нийгмийн толь сонины “Хэн нь хэн бэ” буланд “Худалч Лу” хэмээх нийтлэлд “... моод монголоор дуусдаг шиг амны фигурээр хол явна гэж эндүүрсэн Лу.Гантөмөр Худалч Лу хочтой үлдэх нь...”, ... Татвар төлөгчдийн мөнгийг хэмнэс гэж уриалаад тойрогтоо цөөхөн үзэгдсэн нэр хүндээ энэ мэтээр өсгөж сууна...” гэж бичсэн байхад Өглөөний сонины 2008-03-17 –нд “Ордны шивнээ” булангийн “Эдээрээ оролдвол эвдрэхийн цондон” нийтлэлд эсрэгээр буюу “...Уг нь тойрогтоо хийсэн зүйлтэй, хэлэх үгтэй тэрээр сонгогчдынхоо итгэлийг дааж 2008 оны сонгуулиар намдаа нэг суудал зулгаачих чадалтай нэгэн гэтэл АН-ынхан түүнийг Ху намын час улаан тойрогт сайж чадлыг нь харахаар зэхсэн гэх... Суудал зулгаах чадвартай гишүүнээрээ оролдож байж ганц ч гэсэн суудлаа алдаж нэг тойрогт ялагдал хүлээхээсээ АН-ынхан төдийлөн эмээхгүй байгаа бололтой...” гэхчлэн илт магтсан огт өөр өөр үзэл бодлууд бичигджээ.

Нийгмийн толь сонины 2008-04-03-ны дугаарт ““Ам араак”-аар гүнзгий өвчилсөн эрхэм гишүүн” хэмээх нийтлэлд УИХ-ын гишүүн Д.Одхүүгийн тухай “... Америкт өвчний мөр хөөж явсан эрхэм гишүүн маань харин тэнд хувийн бизнесээ өргөжүүлж, хаус худалдан авсан шигээ гэр орноо тохижуулж явжээ...”, “... Ирэх сонгуулиар Д.Одхүү мэт ам нь хэтэрхий буруу хөгжсөн “ам араак” гишүүн олширвол төрийн механизмд эвдрэл гарч гацах нь элбэгших байх даа...” гэсэн байна.

Түүний тухай Өглөөний сонин хэд хэдэн дугаартаа, тухайлбал 2008-03-27-нд “УИХ-ын гишүүн Д.Одхүүгийн АНУ-д худалдан авсан хаус АТГ-ын анхааралд өртсөнгүй” хэмээх нийтлэлд “... бүх ажлыг... Д.Одхүү хийсэн гэж .... ичих булчирхайгүй бор шувуу нисгэж суудаг гэнэ. Түүнд ийм бүхэл бүтэн баг бий ажээ...”, 2008-04-01-нд “УИХ-ын гишүүдийн тойрогтоо хийсэн хөрөнгө оруулалт” мэдээнд “Д.Одхүү гишүүний тойрогтоо хийсэн хөрөнгө оруулалтыг харвал

“горшокны ёроолд дусаасан хоргол” шиг л харагдаж байна...”, “...Чуулганд суух ёстой ихэнх цагаа АНУ-Монголын хооронд онгоцон дотор үрдэг Д.Одхүүгийн хувьд...”, мөн дугаарт “Орлого нь 1 жилийн дотор 54 саяар нэмэгдсэн Д.Одхүү гишүүн “Эрдэнэт” үйлдвэртэй ямар холбоотой вэ?” нийтлэлд “... ТӨХ-нд газрын дарга байхдаа уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрийн захирлын өрөөнд /Ш.Отгонбилэг агсан захирал нь байсан/ “Одхүүдэж” орсноосоо хойш Эрдэнэт үйлдвэрийг “рекэтлэх” болжээ...” гэх зэрэг цуврал материал нийтэлжээ.

- Бусад хүмүүсийн тухай ч ХМХ нөлөөллийн шинжтэй материалууд байна. Үүнд:

Өнөөдрийн Монгол” сонины “Лүндээгийн ангийнхны 76 өнгө төрх” цуврал нийтлэлээс мониторингийн явцад Л.Гүндалайн тухай “Өрөвдөхгүй байхын аргагүй түшээ”, Б.Бат-Эрдэний тухай “Зөв явсаар зөөлөн суудалд тухалсан түшээ”, М.Сономпилийн тухай “Томоотой түшээ” хэмээх материалууд нийтлэгдсэн бөгөөд тэдгээрт нэр дурдагдсан УИХ-ын гишүүдийн талаар шууд дормжилсон, нэр хүндэд халдсан үг, өгүүлбэр байхгүй боловч бүх материалын өнгө аяс нь тэднийг “төрийн түшээ байж чадахгүй хүн” гэсэн ойлголтыг иргэдэд өгч байгаа юм.

Өглөөний сонины 200/-03-25-ны дугаарын “Т.Билэгтээс өөр боловсон хүчин МАХН-д алга гэж үү?” гэсэн нийтлэлд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Т.Билэгтийн тухай “... Гэвч даахгүй нохой булуу хураана гэгчээр Т.Билэгт дарга нийслэлийг удирдах болсноор хот гэх их айлын хамаг ажлыг цалгардуулж гүйцээд байна” гэж бичжээ.

Мөн сонины 2008-04-03-ны “Дорноговийн МАХН-ын хорооны хуйвалдаанаас болоод бусад аймгуудын хурлыг хойшлуулжээ” гэдэг мэдээнд “...Д.Туяа хатагтай өнгөрсөн он жилүүдэд ийнхүү хор найруулгад л сайтар суралцсан бололтой...”, 2008-04-04-ний дугаарт “Хүний эрхийн хуульч М.Ичинноров хүний зовлонгоор жаргал хийж явна” гэдэг нийтлэлд “...Тэрээр ядарсан Хонгорынхныг өөрийнхөө ПР-д ашиглаж байна. “, “... Эсгий хийх газар нохой хэрэггүй гэгчээр энэ мэтээс өөр хийсэн гавъяагүй тэрээр их хуралд сонгогдохоор санаархаж эхэлсэн нь даанч харамсалтай...” гэж бичсэн байна.

Зууны мэдээ сонины 2008-03-26-ны “Элбэгдоржийн ярьсан кино” нийтлэлд “...Нэг хүний театр нь хоёр хүнийх болж өргөжиж байгаа юм байна. Онгоцны буудал дээр таарсан Нобелийн шагналтнаас гуйж зураг авахуулаад ханандаа өлгөдгөөс энэ удаа арай өөр зорилготой байж. Ц.Элбэгдоржийн мэдэгдэл АН-ын байр суурь биш байсан нь УИХ дахь АН-ын зөвлөлийн мэдэгдлээр нотлогдож байна...” Элбэгдоржийн хувийн тоглолт ийм маягтай өрнөж байна...” , “... Ц.Элбэгдорж мөн л тооноор нь орж ирэн өрмийг нь хамсан болохоос зорилгыг нь хаясан билээ. СТӨ-ний богинохон хүзүүвчээр үнэт зүйлсийн шинэчлэл биш, СТА-ы уран үг л ундарсаар сонгуультай золголоо...” гэжээ.

Ардын эрх сонины 2008-04-01-ний өдрийн дугаарт Ц.Нямдоржийн тухай “Төрийн түшээ юу, гэмт хэргийн мөрдөн байцаагч уу?” гэсэн гарчигтай “... УИХ-ын даргын сэнтийгээс гулгахдаа надаар оролдож байгаа хүнийг би мэднэ. Гэхдээ цагийг нь болохоор дэлгэж тавина гэсэн утгатай зүйл айлдлаа. Энэ нь өөрөө олон дээд тушаалтны нууц бусармаг үйлдлийг мэддэг мөртлөө барьцаалж өөртөө үйлчлүүлж, хахууль өгвөл би чиний булхайг нууж байх болно гэсэн үг биш юм гэж үү?..”, “...Эсвэл Нямдорж өөрөө болон үр хүүхэд нь тэр өв хөрөнгийг бага багаар

хятадын тагнуулын байгууллагад худалдаад байх хэрэг үү?...” гэсэн нийтлэл хэвлэгджээ.

Нийгмийн толь сонины 2009-04-02-нд “Асар, Басар ахин төрлөө” нийтлэлд Ерөнхийлөгч Н.Энхбаяр, УИХ-ын гишүүн М.Энхсайхан, Н.Батбаяр нарын тухай ,... МАХН-ын дарга болсон үеэсээ л Н.Энхбаярын гэж хүн хаа явсан газраа хоёроос доошгүй нохой тэжээж, хэрэгтэй цагтаа турхирч, шуугиулдаг арга барилыг дархан болгож авчээ...”, “... Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлтийн төсөл болов. М.Энхсайхан хамгийн түрүүнд чангаар архирч “хуулийн цоорхой” гэж хуцав...”, “...Фортуна хүүгийн цээжинд хоёрдмол бодол үүсээд уджээ...”, “... М.Энхсайханаас ялгаатай нь Н.Батбаярыг шантаажаар бус урмаар тэжээн...” гэсэн байна.

- Мониторингийн хугацаанд ажигласан сонинуудад сэтгүүл зүйн бичлэгийн ур чадвар муу, зохиогчгүй, эх сурвалжгүй, юу өгүүлэх гэсэн нь тодорхойгүй, хов живийн чанартай материал ч байсныг дурдах хэрэгтэй. Жишээ нь:

Өдрийн сонины 2008-03-14-ний дугаарт “Монгол төр тэднийг яагаад голно вэ?” материалд “... АН, МАХН-аас нэр дэвшигчдийн танил болсон зарим нэг нь хулгай луйвраар нэрд гарч ард түмэнд танигдсан хүмүүс байх юм. Бидний төрийг бидэнд танил хүмүүс барих ёстой. Түүнээс жалга довын хэн гэдгийг нь хэн ч мэдэхгүй дурын хүүхдүүд төр барьж тоглож болохгүй...” гэсэн хоёрдмол утга бүхий нийтлэл хэвлэгджээ. Мөн Өглөөний сонины 2008-03-27-ны дугаарт “Хужаа трубанууд хагарч оршин суугчдыг хохироох боллоо” хэмээх зохиогчгүй нийтлэлд Нийслэлийн ИТХ-ын нэгэн гишүүний талаар өгүүлж, заналхийлсэн маягтай боловч хэн гэдгийг нь бичээгүй, ямар учраас энэ трубатай холбоотой нь ойлгомжгүй байх жишээтэй.

## 6.5 Бичлэгийн төрөл зүйл, эх сурвалж ашигласан байдал

Мониторингийн хугацаанд дээрх 12 сонинд нийтлэгдсэн 2255 бичвэрийг бичлэгийн төрөл зүйлийн хувьд ангилж үзвэл нийт материалын 54,2 хувь нь мэдээ, 31,4 хувь нь нийтлэл, 10,1 хувь нь ярилцлага, 4,3 хувь нь гэрэл зураг, шог зураг бусад материал байна. Харин нийт гарсан 2255 материал дотор ердөө ганц хөрөг байгаа нь 0,04 хувийг эзэлж байгаа юм.

Нийтлэгдсэн материалын дийлэнх нь мэдээ, нийтлэл байгаа нь мөн одоогоор нэр дэвшигчид албан ёсоор тодроогүй, улс төрийн хүчнүүд болон хувь хүмүүсийн мөрийн хөтөлбөр тодорхойгүй байгаатай холбоотой юм. Тиймээс сонинуудад ярилцлага, хөрөг зэрэг төрөл зүйл харьцангуй бага байна.

### Хүснэгт №2. Бичлэгийн төрөл зүйлийн ашиглалт


Сонин	Нийт тоо	Жанр				
		Мэдээ	Хөрөг	Ярилцлага	Нийтлэл	Фото, бусад
<b>НТ</b>	<b>219</b>	54	0	10	151	4
<b>ММ</b>	<b>162</b>	108	0	27	8	19
<b>Ү</b>	<b>140</b>	38	0	24	74	4

Ө	296	146	0	29	113	8
ӨдС	177	38	0	29	103	7
ӨгС	69	45	0	15	1	8
ӨМ	165	88	0	23	36	18
ЗШ	229	41	1	17	166	4
ЗМ	363	330	0	13	9	11
УТ	112	99	0	9	0	4
А	139	114	0	17	2	6
АЭ	184	121	0	14	45	4
<b>Нийт дүн</b>	<b>2255</b>	<b>1222</b>	<b>1</b>	<b>227</b>	<b>708</b>	<b>97</b>
<b>Эзлэх хувь</b>	<b>100</b>	<b>54,2</b>	<b>0,04</b>	<b>10,1</b>	<b>31,4</b>	<b>4,3</b>

Гарч буй материалуудын дийлэнх буюу 61,3 хувь нь ямар ч эх сурвалж ашиглаагүй, мөн ихэнх нь зохиогчгүй тавигджээ. 2 болон түүнээс дээш эх сурвалж ашигласан бичвэр нийт материалын ердөө 3,7 хувь, харин 1 эх сурвалж ашигласан материал 34,9 хувийг эзэлж байна.

**График № 6. Эх сурвалж ашигласан байдал**

61,3 хувь- Огт эх сурвалжгүй  
34,9 хувь – 1 эх сурвалжтай  
3,7 хувь – 2-оос дээш эх сурвалжтай



### 6.5 Хөгжлийн гол асуудлуудыг тусгасан байдал

Сонгуулийн явцад улс орны хөгжил, ардчиллын зарчим, хүний эрхийн тухай асуудал, тэдгээрт улс төрийн намууд, нэр дэвшигчид хэрхэн хандаж буй нь сонгогчдын анхаарлыг ихээхэн татдаг. Одоогоор улс төрийн намуудын мөрийн хөтөлбөр ил тод болоогүй байна. Тиймээс дээрх асуудлуудын талаар тухайн улс төрийн хүчин, нэр дэвшигч ямар үзэл бодолтой байгаа нь мэдэгдэхгүй. Гэвч дор дурдсан асуудлуудыг сонгуультай холбоотой материалд дам байдлаар дурдсан байна.


- Ядуурал
- Архидалт
- Янханчлал, хүний наймаа
- Хүний эрх, хүчирхийлэл
- Улс төрийн эрх, санал бодлоо илэрхийлэх эрх чөлөө, мэдээллийн эрх чөлөө, хэвлэлийн эрх чөлөө, сонгох эрх, жагсаал цуглаан гэх мэт
- Улсын төсөв, санхүү, эдийн засаг
- Авилга, хээл хахууль
- Ардчилал, иргэний нийгэм
- Шударга ёс, хууль эрх зүй, цагдаа, шүүх
- Хөдөө орон нутгийн хөгжил
- Мэдээллийн шинэ технологи
- Эрүүл мэнд
- Боловсрол
- Соёл урлаг
- Шапин
- Хөгжлийн асуудал, уул уурхай, хөрөнгө оруулалт
- Ажиллах хүч, ажлын байр
- Тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал
- Гадаад харилцаа
- Гадаадын зээл, тусламж
- Байгаль, экологи

Эдгээрээс улс төр, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, мэдээллийн эрх чөлөөний тухай сэдэв 300 гаруй удаа буюу хамгийн их хөндөгджээ. Энэ нь нийт материалын 28,3 хувийг эзэлж байна.

Улс төрийн эрх чөлөөний сэдвийн дараа шударга ёс, хууль эрх зүйн сэдэв 148 удаа, уул уурхай, хөрөнгө оруулалтын асуудал 113 удаа дурдагдан орж байна.

Хамгийн бага буюу мониторингод хамруулсан сонинууд, ч улс төрийн хүчин, хувь хүмүүс, боломжит нэр дэвшигчдийн аль алины нь хамгийн бага анхаарал хандуулсан сэдэв нь шапин /1 удаа хөндөгдсөн/, соёл урлагийн асуудал /6 удаа хөндөгдсөн/ байна.

**График № 7. Улс төр, эдийн засгийн ямар асуудлыг хэрхэн хөндсөн байдал**



## Долоо. Дүгнэлт, зөвлөмж

### 7.1 Дүгнэлт

Өдөр тутмын бүх сонин улс орны амьдралын хамгийн чухал, анхаарал татсан улс төрийн үйл явдал болох УИХ-ын сонгуулийн талаар байнга иргэд, сонгогчдод мэдээлж байна.

- Мэдээллийн тоон үзүүлэлтийг авч үзвэл, одоо УИХ-д олон суудалтай, ардчиллын түүхийн хугацаанд ээлжлэн засгийн эрх барьж байсан МАХН, АН-д сонинууд ихэнх зай талбайгаа зориулжээ.
- Мэдээллийн агуулгын чанарын хувьд, дээрх хоёр намд гол төлөв шүүмлэлтэй хандсан байна.
- Мэдээллийн шинжийн хувьд сонинуудад иргэдийн улс төрийн эрхийн талаар түлхүү анхаарсан байна.
- Сонинууд улс орны хөгжлийн гол асуудлуудыг зөвхөн дам байдлаар тусгасан байна. Энэ нь намуудын мөрийн хөтөлбөр ил тод болоогүйтэй холбоотой.
- Мониторингийн дүнгээс үзвэл сэтгүүлчид эх сурвалж бага ашигласан болон огт эх сурвалжгүй материал түлхүү нийтэлсэн байна.
- Төрөл зүйлийн хувьд нийтлэгдсэн материалын дийлэнх нь мэдээ, нийтлэл, харин ярилцлага, хөрөг зэрэг төрөл зүйл харьцангуй бага байна. Энэ нь мөн боломжит нэр дэвшигчид албан ёсоор тодруугүйтэй холбоотой байж болно.

- Сонинууд дээр хүмүүст хулхи, гахай, горшок, хэлгүй, бэлтрэг, шулга гэх мэт элдэв нэр хоч өгөн бичсэн нь сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүйг зөрчиж байгаа явдал нэлээн байгааг харуулж байна.
- Мониторингийн явцад сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой төлбөртэй материал тэмдэглэгдээгүй байна.
- Хэдийгээр “төлбөртэй” гэж тавиагүй боловч нэг хүний тухай дагнан сөрөг материал нийтэлсэн, иргэдийн үг, захиа зэрэг буланд хүнийг доромжилсон, сонгогчдын санаа сэтгэлд нөлөөлж болзошгүй бичвэрүүд нийтлэгдсэн байгаа нь тусгай захиалгат материал байхыг ч үгүйсгэхгүй.
- Түүнчлэн дээр өгүүлсэнчлэн зарим сонин аль нэг намд илт дулдуйдан бусад улс төрийн хүчин рүү дайрч давшилсан агуулгатай нийтлэлүүд бичиж байгаа нь сонгуулийн хууль ёсны бодит сурталчилгааны явцад улам газар авбал уншигч, сонгогчдын эрх ашигт сөргөөр нөлөөлөх вий гэсэн болгоомжлол төрж байна.
- Мониторингийн дүнгээс харвал боломжит нэр дэвшигч гэж үзэж болох 288 хүний нэр тодорч байна. Үүний дийлэнх нь МАХН-ын гишүүн байна.
- Сонгуулийн өмнө сонинууд “Шилдэг 76 улс төрч”, “Итгэл даасан түшээд”, “Шилдэг залуу улс төрчид” гэх мэт санал асуулгыг олон хоногийн турш өдөр тутмын сонинууд дээр тавьж байгаад шалгаруулалтын дүнг мэдээлэхэд олон нийгэд танил бус, шинэ хүмүүсийн нэр олноор гарч ирж байна.

## 7.2 Зөвлөмж

Сонгуулийн өмнөх сонины мониторингийн дүнд үндэслэн бид дараахь зөвлөмжийг санал болгож байна.

- 7.1 Хэвлэл мэдээллийн удирдлага, сэтгүүлчдэд хариуцлагатай сэтгүүл зүй, ялангуяа сонгуулийн сэтгүүл зүйн тухай мэдлэг олгох
- 7.2 Улс төрийн нам, нэр дэвшигчдэд адил тэгш үйлчилж, өөрийн мөрийн хөтөлбөр, нэр дэвшигчдээ танилцуулах боломж олгох,
- 7.3 ХМХ-үүд сонгуулийн тухай мэдээлэх, сурвалжлахад баримтлах ёс зүйн зарчим баталж мөрдөх,
- 7.4 Сонгогчдын боловсролд зориулсан хэвлэл мэдээллийн материалыг мэргэжлийн түвшинд бэлтгэж, сонгогчдын хүртээл болгох,
- 7.5 Төлбөртэй, төлбөргүй сурталчилгааны материалыг ялгагдахуйц байдлаар нийтэлж, нэвтрүүлэх,
- 7.6 ХМХ сонгуулийн үеэр нийгмийн /олон нийтийн/ хоточ нохой байх үүргээ шударгаар биелүүлж, сонгуулийн үйл явцад хяналт тавьж, мэдээллийг сонгогчдод шуурхай хүргэх,
- 7.7 Сонгогчдын санаа бодлыг төөрөгдүүлэхүйц хуудуутай, ташаа, өрөөсгөл мэдээлэл түгээхээс зайлсхийх



## ГЛОБ ИНТЕРНЭШНЛ ТББ

### **Мониторингийн баг:**

Төслийн удирдагч:	Х.Наранжаргал
Ажиглагчид:	Ж.Мөнхсайхан Ж.Энхтуул Б.Онон
Мэдээлэл нэгтгэсэн:	Б.Насанжаргал
Судлаач:	Ч.Мөнхзул
Зөвлөх:	С.Баяр